



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

“Ховд А33А” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Ховд А33А” төрийн өмчит хувьцаат компанийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, гүйцэтгэх захирал Б.Батсүхтэй байгуулсан контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Ховд А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батсүхтэй байгуулах контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



3.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000317